

Н.МӨНХЦЭЦЭГ, ‘НЭР ТОМЬЁНЫ ОРЧУУЛГА СУДЛАЛ’

Редактор Н.Нансалмаа, Улаанбаатар, 2020, 312 тал

Д.Төмөртогоо

ШУА-ийн Хэл зохиолын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, хэл шинжлэлийн ухааны (Ph.D) доктор Н.Мөнхцэцэг Улсын нэр томьёоны комиссоос 1960-1970-аад оны үед боловсруулан гаргасан 110 гаруй мянган нэр томьёо бүхий орос-монгол нэр томьёоны 3 боть толь бичиг болон хожим 1990 оноос хойш нийгэм-хүмүүнлэг, байгаль, техник, технологийн чиглэлээр гарсан 50.000 гаруй үгтэй англи-монгол нэр томьёоны толь бичгийн материал дээр түшиглэн ‘Нэр томьёоны орчуулга судлал’ хэмээх энэхүү бүтээлээ бичжээ.

Доктор Н.Мөнхцэцэг тус бүтээлдээ урьд өмнө төдийлөн хөндөгдөж байгаагүй гадаад нэр томьёоны монгол орчуулгын тухай сэдвийг сонгон авч, түүнийгээ орчин үеийн хэл шинжлэлийн арга зүйн үүднээс дэлгэрүүлэн судалсан нь нэр томьёо судлалд хамгийн тулгамдаж байгаа асуудлын нэг мөн билээ. Зохиогч Ер аливаа нэр томьёо нь шинжлэх ухааны ухагдахууны илэрхийллийн нэгж учраас тэдгээр нь шинжлэх ухааны мэдлэгийн ерөнхий тогтолцоотой нарийн уялдаатай байх ёстой гэсэн зарчмыг баримталж, түүнийгээ нь тодорхой жишээ баримтаар нотлон харуулсан нь салбарын эрдэмтэн, судлаачдад санаа авахуйц чухал ач холбогдолтой болсон гэж үзэж байна. Удиртгал, гурван үндсэн бүлэг, хавсралт хэсгээс бүрдсэн тус бүтээл нь агуулгын хувьд цэгцтэй, арга зүйн хувьд боломжийн сайн бүтээл болжээ.

Урьд өмнө нэр томьёо судлалын талаар нэлээд бүтээл гарсан боловч нэр томьёоны орчуулгыг хэл шинжлэлийн үүднээс авч үзсэн ганц сэдэвт бүтээл гараагүй байсан билээ. Доктор Н.Мөнхцэцэгийн энэхүү ганц сэдэвт зохиолдоо монгол нэр томьёоны талаар урьд өмнө гарсан судалгааны бүтээлүүдийг харьцуулан үзээд, улмаар гадаад хэлний нэр томьёог эх хэлээрээ хэрхэн орчуулах арга замыг тодорхойлох зорилго тавьснаараа өмнөх судалгааны үр дүнг урагш ахиулж, нэр томьёоны орчуулга судлалаар дагнан бичсэн анхны ганц сэдэвт бүтээл болсон байна. Зохиогч уул бүтээлийг бичихийн тул нэр томьёо, орчуулга судлал, танин мэдэхүйн шинжлэх ухааны чиглэлээр гадаад, дотоодод гарсан бүтээлүүдийг шүүрдэн үзэж, судалгаандаа ашигласан нь эшлэл болон ном зүйгээс нь тодорхой харагдаж байна.

Аливаа хэлэнд гадаад үгийг орчуулахдаа утга дүйцүүлэх боломжгүй байвал хэд хэдэн үгээр тайлбарлан орчуулах, эсвэл шууд зээлдэн хэрэглэх тохиолдол нийтлэг байдаг. Монгол улс зах зээлийн нийгэмд шилжсэн 1990-ээд оноос хойш даяаршлын хэл болсон англи хэлний үг, нэр томьёог үгийн сандаа оруулан хэрэглэх нь нэлээд нийтлэг шинжтэй болж байгаа боловч тэдгээрийг хэрхэн буулгах дүрэм журам одоо хүртэл нэгэн мөр болж тогтоогүй байгаа билээ. Доктор Н.Мөнхцэцэг энэхүү хэрэгцээ шаардлагыг олж ажиглаад, англи үгийг галигчлан буулгах журам боловсруулснаа Хавсралт-1-ээр, европ гаралтай нэр томьёонд олонтоо тохиолддог грек, латин гаралтай үгсийг монгол хэлээр хэрхэн илэрхийлэх боломжийн талаар Хавсралт-2-оор тус тус үзүүлсэн байна. Тэдгээр хавсралтад багтаасан тогтолцоог цаашид улам нягтлан боловсруулаад гадаад хэлний нэр томьёог орчуулах баримжаа стандарт тогтоох боломжтой мэт санагдлаа.

Тыашрамд дурдахад, доктор Н.Мөнхцэцэг нэр томъёоны орчуулгын асуудлыг орчин үеийн хэл шинжлэл дэх когнитив тогтолцооны үүднээс авч үзсэн ‘Нэр томъёоны тогтолцоот шинж ба орчуулгыг танин мэдэхүйн хэл шинжлэлийн үүднээс судлах нь’ гэсэн өгүүлэл бичиж ‘Хэрэглээний хэл шинжлэл’ цувралд нийтлүүлсэн нь өндрөөр үнэлэгдэж, 2019 оны ‘шилдэг өгүүлэл’-ийн шагнал хүртсэн билээ.

Н.Мөнхцэцэг энэхүү ганц сэдэвт зохиолдоо шинжлэх ухааны нэр томъёог монгол хэлээрээ оноон орчуулах эрэл хайгуул хийж, бодит нөөц боломжийг эрэлхийлсний дээр үгсийн сан, нэр томъёоны судлалд тохирох зохистой арга зүй боловсруулсан байна.